



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/144

Алтай хот

Илүү цагаар ажиллуулбал
нэмэгдэл олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдыг холбогдох хууль, байгууллагын дотоод журмаар тогтоосон өдрийн ажлын цагийг ажил олгогчийн санаачилгаар хэтрүүлэн ажиллуулахгүй байхыг төрийн байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт даалгасугай.

2.Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын дагуу илүү цагаар ажиллуулбал нэмэгдэл хөлсийг тооцож олгохыг төрийн байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж тайлагнаж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР